



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Эрсдэлд суурилсан аргачлал


САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

Эрсдэлийн үнэлгээ



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ФАТФ Зөвлөмж 1
Эрсдэлийг үнэлэх, эрсдэлд
суурилсан аргачлал ашиглах



ФАТФ Зөвлөмж 1

- Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нь өөрийн МУТС, ҮОХЗДС эрсдэлийг тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

МУТСТ хууль 4.3

- Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг **эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх** бөгөөд ийнхүү хэрэгжүүлэхдээ өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн **эрсдэлийг бодитойгоор үнэлнэ.**

Эрсдэлд суурилсан аргачлал



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Эрсдэлээ тодорхойлж,
үнэлэх

- Харилцагч, үйлчилгээ, газар зүйн болон үйлчилгээний сувагтай холбоотойгоор байгууллагад тулгарч буй МУТС эрсдэлийг тодорхойлох

Эрсдэлийн удирдлага
ба эрсдэлийг бууруулах

- МУТС эрсдэлийг үр дүнтэй удирдах, бууруулах арга хэмжээг тодорхойлж, авч хэрэгжүүлэх

Тогтмол хяналт

- МУТС эрсдэлд гарсан өөрчлөлтийг хянах бодлого, журам, системийг бий болгох

Баримтжуулалт

- МУТС эрсдэлийг хянах, удирдах, бууруулах эрсдэлийн үнэлгээ, стратеги, бодлого, журмыг баримтжуулах

Эрсдэлээ тодорхойлж, үнэлэх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МУТС эрсдэлийн
үнэлгээний мөн
чанар, цар хүрээ



Бизнесийн төрөл,
үйлчлүүлэгчдийн
шинж чанар, үйл
ажиллагааны
ХЭМЖЭЭ

Эрсдэлийн үнэлгээнд тавих шаардлага



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Эрсдэлийн үнэлгээ:

таны
бизнесийн
явцад учирч
болзошгүй
МУТС
эрсдэлийг
тодорхойлох
ёстой

харилцагч,
бүтээгдэхүүн
үйлчилгээ, улс
оронтой
холбоотой
эрсдэлийн
түвшинг
тодорхойлсон
байх ёстой.

зохицуулагч
байгууллагаас
гаргасан
шаардлагыг
хангасан байх
ёстой.

-г
баримтжуулсан
байх ёстой.

-г ашиглан
дотоод
хяналтын
хөтөлбөр
боловсруулах
ёстой.

-г тогтмол
хянаж,
дутагдлыг
илрүүлж,
шаардлагатай
өөрчлөлтийг
хийж байх
ёстой.

эрх бүхий
байгууллага,
хянан
шалгагчдыг
мэдээллээр
хангах ёстой.

Эрсдэлийн үнэлгээнд тавих шаардлага



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



Эрсдэлээ тодорхойлж, үнэлэх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Харгалзаж
үзэх
эрсдэлийн
хүчин
зүйлс

Үндэсний эрсдэлийн үнэлгээний дүгнэлт

Салбарын эрсдэлийн үнэлгээ

Зохицуулагч байгууллагаас танай салбартай холбоотой гаргасан журам заавар, гарын авлага

Үйл ажиллагаа явуулдаг бусад улс орнуудын эрсдэлийн тайлан

Эрсдэлийн түвшинг үнэлэхэд хамаарах бусад мэдээлэл

Эрсдэлээ тодорхойлж, үнэлэх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

- МУТСТ тухай хуулинд өндөр эрсдэлтэй харилцагч гэж заасан уу?
- Тохиолдлын чанартай эсвэл нэг удаагийн тодорхой хязгаараас давсан өндөр дүнтэй гүйлгээнд оролцдог уу?
- Санхүүгийн ямар нэг ашиг тусгүй хэр нь бизнесийн нарийн төвөгтэй бүтцийг ашигладаг уу?
- УТНБЭ мөн үү?
- Бэлэн мөнгө их эргэлддэг бизнес мөн үү?
- Авлига, хээл хахууль ихтэй бизнестэй холбоотой юу?
- Тайлбарлах боломжгүй, эх үүсвэрийг нь баталгаажуулахад хэцүү хөрөнгө, мөнгө байгаа юу?
- Нягтлан бодогч, хуульч эсвэл бусад мэргэжлийн хүмүүсээр дамжуулан бизнесээ явуулж байна уу эсвэл ийм этгээд анх зуучилж танилцуулсан уу?
- Ашгийн бус байгууллага мөн үү?
- Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээ, СМА, бусад зохицуулагч байгууллагаас МУТС өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон уу?

Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



Улс төрд нөлөө бүхий этгээд;



МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;



Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.



Энгийн бус нөхцөлд үүсгэсэн бизнесийн харилцаа/Жишээлбэл гадаад улсаас биеэр ирэлгүй үүсгэж буй бизнесийн харилцаа/;



Оршин суугч бус харилцагч;



Харилцагч нь хөрөнгийг удирдах хэлцлийн дагуу хөрөнгийг хариуцаж байгаа этгээд;




Өмчлөлийн ер бусын эсвэл хэт нарийн төвөгтэй бүтэцтэй хуулийн этгээд


Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК




Бэлэн мөнгө их эргэлддэг бизнесүүд, тухайлбал, хүргэлтийн хоолны газар, жижиглэнгийн худалдааны дэлгүүр, машин угаалга, үсчин, бар, ресторан г.м



Үнэт эдлэл, автомашин, уран зураг, эртний эдлэл, тансаг зэрэглэлийн барааны дэлгүүр



Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, алт, алмаз зэрэг үнэт металлийн худалдаа, буяны байгууллагууд



Гэмт хэрэгт холбогдож байсан, эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээлэл гарсан этгээд

Газар зүйн байршил, бүс нутгаас хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК


эд баялаг, хөрөнгийн эх үүсвэрийн гарал үүсэл, одоогийн байршил

үйлчилгээ үзүүлж буй газар

тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан улс

үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны гол байршил

эцсийн өмчлөгчийн оршин суугаа улс



ФАТФ-аас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй гэж тодорхойлогдсон

НҮБ г.м олон улсын байгууллагын санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалт болон ижил төстэй арга хэмжээнд орсон

Найдвартай эх сурвалжаас авлига хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон

Найдвартай эх сурвалжаас тухайн улс орон эсхүл бүс нутаг нь терроризмыг санхүүжүүлдэг, террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг эсхүл террорист бүлэглэл үйл ажиллагаа явуулдаг гэж тодорхойлогдсон

Газар зүйн байршил, бүс нутгаас хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

- ❑ ФАТФ-ын эрсдэл өндөртэй болон стратегийн ноцтой дутагдалтай улс орны жагсаалт (<https://www.fatf-gafi.org/en/countries/black-and-grey-lists.html>)
- ❑ ФАТФ-ын харилцан үнэлгээний тайлан
- ❑ Европын Холбооны мөнгө угаах болон татварын хар жагсаалт
- ❑ Базелийн мөнгө угаахтай тэмцэх индекс (<https://index.baselgovernance.org/>)
- ❑ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн газар (UNODC)-ын тайлангууд
- ❑ Транспэрэнси Интернэшнлээс гаргасан авлигын төсөөллийн индекс (<https://www.transparency.org/>)
- ❑ Итгэмжлэгдсэн, хараат бус хэвлэл мэдээллийн эх сурвалж
- ❑ НҮБ-ын хориг арга хэмжээ.

Бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь нэрээ нууцлах боломжтой юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь гуравдагч этгээд рүү төлбөр төлөх боломж олгодог үү?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь ихэвчлэн бэлэн мөнгө хүлээн авах, бэлэн мөнгөөр төлбөр төлөх боломжтой байдаг уу?
- Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээ, СМА болон бусад зохицуулах байгууллагаас гаргасан баримт бичигт тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээг МУТС өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь хил дамнан хөрөнгө, мөнгө шилжүүлэх боломж олгодог уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь их хэмжээний гүйлгээг богино хугацаанд хийх боломж олгодог уу?
- Харилцагч нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн хараа хяналт багатайгаар тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээний тусламжтай гүйлгээ хийх боломжтой юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь маш өндөр дүнтэй гүйлгээ эсвэл хөрөнгө оруулалтын үнэ цэнэтэй юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь ер бусын нарийн төвөгтэй байдаг уу?

Бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



Зайнаас үүсгэсэн бизнесийн харилцаа (утас, интернет г.м суваг ашиглах)



Хил дамнан үзүүлэх үйлчилгээ



3-дагч этгээдээр зуучлуулан эхлүүлсэн харилцаа



Харилцагчийн талаар хангалттай мэдээлэл авахгүйгээр үзүүлэх боломжтой санхүүгийн эсхүл татварын зөвлөх үйлчилгээ



Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны талаар зохих мэдлэггүйгээр түүний байр суурь, нэр хүнд, найдвартай байдлыг гуравдагч этгээдэд төлөөлөх эсвэл баталгаажуулах үйлчилгээ.



Агент, төлөөлөгчөөр дамжуулан шууд бусаар үзүүлэх үйлчилгээ

Эрсдэлийн үнэлгээ хийх арга



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

А. Магадлал, үр дагаврыг тооцох

Тохиолдох магадлал	5 Маш өндөр	11	16	20	23	25
	4 Өндөр	7	12	17	21	24
	3 Болзошгүй	4	8	13	18	22
	2 Бага	2	5	9	14	19
	1 Ховор	1	3	6	10	15
		1 Маш бага	2 Бага	3 Дунд	4 Их	5 Ноцтой
Үр дагавар						
Эрсдэлийн үнэлгээ	БАГА	ДУНД	ӨНДӨР	МАШ ӨНДӨР		

Тоон болон чанарын мэдээлэлд үндэслэнэ.

Эрсдэлийн үнэлгээ хийх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



Эрсдэлийн үнэлгээг хийх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Харилцагчид санал болгож буй бүх төрлийн үйлчилгээ, тухайн үйлчилгээг хүргэж буй арга хэлбэр, сувгийг тодорхойлох

Эдгээр үйлчилгээг гэмт хэрэгтнүүд мөнгө угаах зорилгоор ашиглах боломжтой эсэхийг үнэлэх

Тодорхойлсон эрсдэл тус бүрийг удирдах, бууруулах арга хэмжээг тодорхойлох

Эрсдэлийн үнэлгээг хийх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Харилцагчдын үйл ажиллагаа явуулж буй, санхүүжилт авдаг, бараа үйлчилгээгээ нийлүүлдэг, түүхий эд худалдан авдаг газар зүйн байршлуудыг тодорхойлно



Эдгээр улс оронтой холбоотой МУТС эрсдэлийг үнэлнэ



Эрсдэл тус бүрийг удирдах, бууруулах арга хэмжээг тодорхойлно

БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ				
Харилцагч – харилцагчийн төрлүүд	МУТС эрсдэл тохиолдох магадлал	МУТС эрсдэл үүсэн үед гарах үр дагавар	МУТС эрсдэлийн түвшин	Эрсдэлийг удирдах, бууруулах арга
5 ТӨХК	Ховор	Бага	Бага	ХТМ энгийн үйл ажиллагаа
70 жижиг бизнес, компаний энгийн бүтэцтэй	Болзошгүй	Бага/дунд	Дунд	ХТМ энгийн үйл ажиллагаа
БНХАУ-д үүсгэн байгуулагдсан 10 хуулийн этгээд	Болзошгүй	Дунд	Дунд	ХТМ энгийн үйл ажиллагаа
8 дундаж бизнес (1-2 нь УТНБЭ-тэй холбоотой байж болзошгүй)	Өндөр	Их	Өндөр	ХТМ өргөтгөсөн үйл ажиллагаа
25 жижиг бизнес /ресторан, үнэт эдлэл, үл хөдлөх/	Маш өндөр	Их	Ноцтой	ХТМ өргөтгөсөн үйл ажиллагаа Орлогын эх үүсвэрийг шалгах Гүйлгээг хянах


Газар зүйн байршил / харилцаа хамааралтай улс орон	МУТС эрсдэл тохиолдох магадлал	МУТС эрсдэл үүсэн үед гарах үр дагавар	МУТС эрсдэлийн түвшин	Эрсдэлийг удирдах, бууруулах арга
ФАТФ-ийн гишүүн улс дахь харилцагч	Ховор	Дунд	Дунд	ХТМ энгийн үйл ажиллагаа
Хойд Солонгосоос хөрөнгө оруулалттай харилцагч	Маш өндөр	Их	Ноцтой	ХТМ өргөтгөсөн үйл ажиллагаа Орлогын эх үүсвэрийг шалгах Гүйлгээг хянах

Эрсдэлийн үнэлгээ хийх арга



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Б. Төрөлх эрсдэл, эрсдэлийг удирдах арга хэрэгслийг үнэлэх



Эрсдэлийн үнэлгээ хийх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Төрөлх эрсдэлийн түвшин	Оноо
Маш өндөр	5
Өндөр	4
Дундаж	3
Бага	2
Маш бага	1

Эрсдэлийн хяналтын чанар	Оноо
Маш хүчтэй	0.10 (90% эрсдэлийг бууруулна)
Хүчтэй	0.30 (70% эрсдэлийг бууруулна)
Дундаж	0.50 (50% эрсдэлийг бууруулна)
Сул	0.70 (30% эрсдэлийг бууруулна)
Маш сул	1.00 (эрсдэлийг бууруулдаггүй)

Эрсдэлийн үнэлгээ хийх



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

1. Төрөлх эрсдэл \times Хяналтын үр нөлөө = Үлдэгдэл эрсдэл
2. Эрсдэлийн хүчин зүйл бүр дэх үлдэгдэл эрсдэлийн нийлбэр \div Эрсдэлийн хүчин зүйлийн тоо = Нийт үлдэгдэл эрсдэл.

Түвшин	Тайлбар
Маш өндөр / 5 ба түүнээс бага, 4-өөс их /	МУТС үйл ажиллагаанд оролцох, эсвэл ийм үйл ажиллагаа явуулах магадлал өндөр, томоохон эрсдэлд анхаарал хандуулдаггүй, эрсдэлийн хяналт үр дүнтэй байдаггүй, эсвэл хяналтын үйл ажиллагаа нь үр дүнгүй байдаг.
Өндөр / 4 ба түүнээс бага, 3-аас их /	МУТС үйл ажиллагаанд оролцох, өртөх магадлал дунджаас дээгүүр, эсвэл холбогдох хяналтын үйл ажиллагаанд сул тал их байна. Томоохон эрсдэлийг үнэлээгүй, хяналт үр дүнтэй биш эсвэл хяналтын үйл ажиллагааны гүйцэтгэл нь хангалтгүй байж болно. Эрсдэлийн түвшинг хяналтын бодлого, үйл ажиллагаагаар бага зэрэг бууруулдаг.
Дундаж / 3 ба түүнээс бага, 2-оос их /	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох магадлал дунд зэрэг, эсвэл хяналтын үйл ажиллагаанд зарим сул тал бий. Эрсдэлийг ерөнхийд нь удирддаг бөгөөд холбогдох хяналт нь ерөнхийдөө үр дүнтэй байдаг ч тодорхой хэсгийг сайжруулах шаардлагатай байна. Эрсдэлийн түвшинг хяналтын үйл ажиллагааны тусламжтайгаар эрс багасгадаг.
Бага / 2 ба түүнээс бага, 1-ээс их /	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох нь бага. Эрсдэлийг ерөнхийд нь зөв удирдаж байгаа бөгөөд хяналт нь МУТС эрсдэлийн ихэнх хэсгийг үр дүнтэй бууруулдаг.
Маш бага / 1 ба түүнээс бага /	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох эрсдэл маш бага байна. Эрсдэлийг зохих ёсоор удирддаг бөгөөд хяналт нь МУТС эрсдэлийг үр дүнтэй бууруулдаг.

Төрөл	Төрөлх эрсдэл (1-5)	Эрсдэлийн үнэлгээний тайлбар	Бууруулах/Хяналтын арга хэмжээ	Үлдэгдэл эрсдэлийн оноо
Харилцагчийн эрсдэл				
Монгол улсын иргэн	2	...	0.1	0.2
Гадаад улсын иргэн	3	...	0.5	1.5
Улс төрд нөлөө бүхий этгээд	5	...	0.7	3.5
Хэт нарийн төвөгтэй өмчийн болон хяналтын бүтэцтэй хуулийн этгээд	5	...	1	5
Бэлэн мөнгө шаарддаг/ эрсдэлтэй салбар эсвэл бизнест үйл ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгчид	5	...	0.5	2.5
Ашгийн бус байгууллага	3	...	0.3	0.9
Бүтээгдэхүүн/үйлчилгээний эрсдэл				
Газарзүйн эрсдэл				
Сувгийн эрсдэл				
НИЙТ ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛ	$(0.2+1.5+3.5+5+2.5+0.9)/6=2.7$		ДУНДАЖ	

Дотоод хяналтын хөтөлбөр



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



**Төлөөлөн
удирдах зөвлөл,
гүйцэтгэх
удирдлага**

APPROVED

Дотоод хяналтын хөтөлбөр



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

1

Эрсдэлийг үнэлэх аргачлал

2

Бага, дунд, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам

3

Өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт

4

Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт

5

Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, СМА болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх журам

6

Баримт бичиг хадгалах

7

Комплаенсийн ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

8

Дотоод сургалтын хөтөлбөр



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Анхаарал тавьсанд баярлалаа